

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

### ТЕЛЕВИЗИЙН ЯРИЛЦЛАГА, ТОК ШОУД ХИЙСЭН ЗАРИМ АЖИГЛАЛТ ДҮГНЭЛТ

(“Монгол тулгатны 100 эрхэм”, “Одод түгэх цаг” нэвтрүүлгийн жишээн дээр)

Хаварцэцэг\* ( БНХАУ)

\*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант

**Түлхүүр үг:**ток шоу, теле ярилцлага, мэдээллийн багтаамж, эх сурвалж, агуулга ба хэлбэр, хөтлөгчийн ур чадвар, нэвтрүүлгийн рейтинг

**Х**IX зууны дунд үе хүртэл Европ, Америкийн сэтгүүл зүйд ярилцлага түгээмэл бичлэгийн төрөл зүйл болж хараахан чадаагүй байв. Сэтгүүлчид мэдээлэл олж авах зорилгоор улс төрчид, дипломатуудтай ярилцаж байсан боловч зөвхөн ярилцлагын гол агуулгыг дамжуулж мэдээллийн эх сурвалжийг дурдахгүй өнгөрдөг байжээ. 1870-аад оны дунд үе хүртэл ярилцагчийн хэлсэн үгийг зөвхөн шууд ишлэл маягаар тусгадаг практик түгээмэл байв. 1880онд Ж.Супинсоны К.Маркстай хийсэн ярилцлага нь “Капитал”-ыг зохиогчийн хэд хэдэн жижиг шууд ишлэлээс бүрдсэн нь үүний тод жишээ юм<sup>1</sup>. Гэхдээ XIX зууны сүүлчийн 10 жилд ярилцлага АНУ-ын сэтгүүл зүйд нэлээд түгээмэл төрөл зүйлийн нэг болж хувирсан юм.1890-ээд он гэхэд ярилцлага Нью-Йоркийн сонинуудын бичлэгийн гол төрөл зүйл болон хувирч, сэтгүүлчид, улс төрчид, Ромын пап лам, Английн болон Германы сайд нарын кабинетийн гишүүд, гадаадын зочин

төлөөлөгчдөөс ярилцлага авч нийтлүүлдэг нь түгээмэл болжээ.

Британийн нэрт сэтгүүлч У.Стид 1902 онд ярилцлагыг “Америкийн мөн чанарыг илэрхийлсэн нээлт”<sup>2</sup> гэж нэрлэсэн байдаг. Тэрээр Америкийн хэвлэлийн тушлагыг үндэслэн бичсэн ярилцлагын анхны үлгэр жишээг Англид явуулж байсан юм. 1927 онд АНУ-ын сэтгүүл зүйн тухай ном бичсэн Германы сэтгүүл зүйн онолч Э.Довифат ярилцлага бол цэвэр Америкийн нээлт гэдгийг хүлээн зөвшөөрсөнбайдаг. Энэ бүхнээс үзэхэд өнөөдөр хүн бүхний мэддэг, сэтгүүлч болгоны сонирхон бичиж, бэлтгэдэг ярилцлага тухайн үед сэтгүүл зүйн салбарт гарсан нээлтийн хэмжээнд үнэлэгдэж байжээ.

“Асуулт-хариулт”хэмээх өвөрмөц зохиомжоор хийгдсэн ярилцлагын төрөл нэвтэрсэн нь уншигчдын тухайн сониныг хүлээн авах байдал, зохиогч-сэтгүүлч болох бие хүний байр суурь тодорхой хэмжээгээр өөрчлөгдөхөд нөлөөлжээ.Учир нь уншигчдын анхаарлыг зөвхөн ярилцагч төдийгүй, ярилцлага хийж буй зохиогчийн онцлог шинж татах болсон юм. Урьд уншигчдад бие хүн болох онцлог нь огт мэдэгдэхгүй өнгөрдөг байсан сэтгүүлч

аажим аажмаар өөрийн гэсэн онцлог шинж, дүр төрхийг харуулж, нийгмийн нэг бие хүн болох онцлогийг илэрхийлж чаддаг болжээ. Түүний оюуны чадавхи, егөөдөл, ингүүхэн үг, ярилцагчаас мэдээлэл олж авах, маргаан мэтгэлцээн өрнүүлэх авьяас чадвар зэрэг нь хүлээн авагчдын зүгээс зохиогчийг хүндэтгэх, үнэлж цэгнэх хандлагыг бий болгоход нөлөөлсөн юм. Тухайн үеийн “нийгмийн шилдэг” хүмүүстэй уулзаж, ярилцлага авч буй сэтгүүлч тийм хүчтэй, нэр хүндтэй хүмүүстэй ойр дотно байдгийг илэрхийлэх замаар өөрийнхөө нийгмийн байр суурь, нэр хүндийг дээшлүүлэх боломжтой болжээ.

**С**үүлийн жилүүдэд телесэтгүүл зүйн хөтөлбөрт ярилцлагын өвөрмөц төрөл болох ток шоу маягийн нэвтрүүлгүүд томоохон байр эзлэх болов. Үүнийг Монгол Улсын “UBS” телевизийн “Сайн уу, Сайнаа”, “MNB” телевизийн “Нандин”, “NTV” телевизийн “Болзоо”, “SBN” теле-визийн “Бүсгүйн ааль” зэрэг ток шоу маягийн нэвтрүүлгүүдээс харж болно. ӨМӨЗО-ы “Одон” телевизэд “Одод түгэх цаг”, “Шүлэг бид хоёр” зэрэг үзэгчийн сонирхлыг татсан чанартай нэвтрүүлгүүд гараад удаж байна.

Ток шоу бол хэд хэдэн оролцогч хөтлөгчийн дэвшүүлсэн сэдвийн дагуу ярилцаж, санал бодлоо солилцох телевизийн нэвтрүүлгийн төрөл юм<sup>3</sup>. “Сонгодог маягийн ток шоу хөтлөгч, уригдсан ярилцагч буюу шинжээч, студи дэх үзэгч хэмээх гурван холбоосоос тогтдог. Ток шоу сэтгүүл зүйн болон тайзны арга барилыг хосолсон байдгаараа онцлогтой. Түүний оролцогч болгон хөтөлбөр доторхи албаны үүргээс үл шалтгаалан нэгэн зэрэг ток шоуны баатар болон хувирдаг”<sup>4</sup>. Ижил төрлийн студийн ярилцлагуудаас

ялгарах онцлог нь үзэгч гурав дахь оролцогч болдог. Студид ирсэн үзэгч ток шоуны гол гурван холбоосын нэг байна. Ток шоу гурвалсан харьцаан дээр тогтоно. Энэ нь хөтлөгч, оролцогч, үзэгч юм. Дээрх үндсэн гурван харилцаанаас гадна оролцогч болон хөтлөгч, үзэгчийн аль алины талд үл орох тухайн асуудалд мэргэжлийн үүднээс хандах шинжээчийг оролцуулдаг. Энэ нь ток шоу хэт сэтгэл хөдлөлтэй, асуудалд хийсвэр хандах байдлыг тэнцвэржүүлж өгдөг ач холбогдолтой юм. Ток шоу шууд явж байгаа үед телевиз үзэгчийг шууд утас буюу захидлаар(мессежээр) оролцуулж болно. Зарим судлаачийн тэмдэглэснээр ток шоуны зорилго нь маргаан мэтгэлцээн өрнүүлэх, хурц асуулт тавих, янз бүрийн үзэл бодлыг уралдуулах замаар үзэгчдийг идэвхжүүлэх, нэвтрүүлгийн агуулгыг улам сонирхолтой болгоход оршдог байна. Орчин үеийн ток шоуны заль мэх нь гадна талаас нь харахад чөлөөт мэтгэлцээн юм шиг мөртлөө үнэн хэрэг дээрээ үзэгчдэд тодорхой хэмжүүрүүдийн хүрээнд захирагдсан цорын ганц байр суурийг тулган хүлээлгэхэд чиглэгддэг<sup>5</sup>. Үүний тод жишээ бол ОХУ-ын телевизийн “Тема” (“Сэдэв”), “Место Встречи” (“Болзоо”), “Время покажет” (“Цаг хугацаа харуулна”) ток шоу юм.

Дэлхийн хамгийн анхны ток шоу зохиогч нь Америкийн сэтгүүлч Фил Донахью гэж үздэг. 1967 онд “Шоу Фил Донахью” нэвтрүүлгийн үеэр цаг нь болоогүй байхад оролцогчоос асуух асуулт нь дууссан учраас санамсаргүйгээр студид байсан үзэгчдэд хандсан байна. Оролцогчоос асуух асуулт үзэгчдэд маш их байж, ингээд Фил Донахьюгийн шоу ч амжилттай болж ток шоу маягийн нэвтрүүлгийн эх суурийг тавьсан түүхтэй юм.

Ток шоу нь хөтлөгч төвтэй телевизийн олон төрлийн нэвтрүүлгийн нийлэмж юм. Бусад төрлийн нэвтрүүлгийг бодвол хөтлөгчийн хувийн шинжтэй нэвтрүүлэг. Хөтлөгч үйл явдлын цөм байж, сэдвийн өгөгдөл, агуулга, гаргалгааг чиглүүлж өгөхөд чухал үүрэгтэй. Тиймээс хөтлөгчөөс сэргэлэн байдал, хошин шогийн мэдрэмж, үг ярианы баялаг, хүний нүдэнд аятайхан харагдах гаднах дүр төрх, өөрийн гэсэн онцлогийг шаарддаг. Ток шоу тогтмол байх нь чухал. Ингэснээр телевиз үзэгч ток шоу эхлэх цагийг хүлээж, дэвшүүлж тавьсан асуудалд өөрийн зүгээс хандахад сэтгэл зүйн хувьд бэлтгэгдсэн байна. Ток шоуны гурвалсан холбооны нэг болсон студийн үзэгчдийг хоёр ангилж болно. Эхнийх нь нэвтрүүлгийг сонирхолтой болгох зорилгоор зохион байгуулагчдын зүгээс оруулж буй жүжигчин-үзэгч юм. Үзэгчдийн дунд сууж шаардлагатай үед ток шоууг сонирхол татахуйц, хөгжөөнтэй болгоход чухал үүрэг гүйцэтгэнэ. Олны танил бус болон зарим тохиолдолд нэр алдартай хүмүүс ч үзэгчийн суудалд суух нь бий. Ийм төрлийн үзэгчдийг мэргэжлийн үзэгч гэж нэрлэдэг. Телевизийн нэвтрүүлэг бэлтгэж байгаа уран бүтээлч нар “массовка” гэж нэрлэгдээд байгаа нэвтрүүлгийн танхимд суух үзэгчдийг цуглуулах ажлыг хийдэггүй. Нэвтрүүлгийн танхимд суух үзэгчдийг олох ажлыг тусгай төлөөлөгч (агент) хариуцан ажилладаг. Оросын “Виор” агентлаг “Первый канал”, “Россия”, “ТНТ”, “СТС”, “Муз ТВ” зэрэг телевиз, “Мосфильм”, “Амедиа” зэрэг кино студид хэрэгцээт жүжигчин нийлүүлэх ажил хийдэг байна. Нөгөө хэсгийн үзэгчид нь телевизээр байнга явдаг ток шоундаа өөрийн биеэр оролцож, санал бодлоо илэрхийлэхийг хүссэн хүмүүс байж

болно. Дэлхийн томоохон телевизүүд олон жил гарч буй, үзэгч ихтэй ток шоуны студийн үзэгчийн суудлын тасалбарыг борлуулдаг практик бий.

**С**үүлийн жилүүдэд ток шоуны төрөл, хэлбэр улам баяжиж телемост (телегүүр), телемэтгэлцээн, телеярилцлага, телехэлэлцүүлэг-маргаан зэрэг холимог шинжтэй хэлбэрүүд бий болжээ.

Ток шоууг сэдвийн хувьд дараах хэдэн төрлөөр ангилж болно.

- Нийгмийн анхаарал татсан сэдэвт ток шоу. Улс төр, эдийн засаг, нийгмийн амьдрал, шоу бизнес гэх зэрэг олон нийтийн анхаарлыг татаж, ярианы гол сэдэв болдог асуудлыг дэвшүүлэх юм. Нийгмийн бүх давхаргын эрх ашгийг хөндсөн, тэр дундаа тухайн ток шоуны боломжит үзэгчдийн хүрээг бүрэн хамарч чадахуйц байна. Энэ төрлийн токшоуг нэвтрүүлгийн сүлжээнд оройн цагаар ихэвчлэн зарладаг. Хөтлөгчийн нэр хүнд, олонд танигдсан байдал нь нэвтрүүлгийн рейтингэд чухал нөлөөтэй. Олны танил жүжигчин, эсвэл улс төрч, нийгмийн ямар нэгэн салбарын нөлөө бүхий хүн байх нь элбэг.

-Сэтгэл зүйн ток шоу. Хүний хувийн амьдралыг илүүтэй хөндсөн, “эмэгтэйчүүдийн” гэж нэрлэгддэг сэдвийг сонгон авч хийдэг төрөл юм. Гэр бүл, гоо сайхан, ажил мэргэжил, хайр дурлал гэх мэт. Сэтгэл зүйн ток шоу хийж байгаа тохиолдолд хэн үзэх вэ гэдгийг сайтар тооцоолох шаардлагатай. Энэ төрлийн ток шоууг эмэгтэйчүүд үздэг учраас эфирт гаргахдаа өдрийн цагийг сонгодог нь түгээмэл юм.

-Тусгайлан мэргэшсэн сэдэвт ток шоу. Анх сонгож авсан сэдвээсээ гажилгүй нэг төрлийн асуудлыг олон талаас нь хөндөнө. Хоолны, эрүүл мэндийн, хүүхдийн гэсэн сэдвүүд түгээ-

мэл байдаг. Зорилтот үзэгчдийн хүрээ харьцангуй хязгаарлагдмал учраас өглөө болон өдрийн цагаар эфирт гаргадаг.

- Холимог болон үйл явдлын сэдэвт ток шоу. Энэ төрлийн ток шоуны сэдэв дээрх гурван төрлийн аль нь ч байж болно. Эсвэл сонгууль хэрхэн болж өнгөрсөн, энэ үеэр ашигласан хар PR ямархуу нөлөө үзүүлсэн, үнэн бодитой мэдээлэл байсан зэрэг сэдвийг сонгож болох юм.

“**М**онгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлгийг 2011 оноос бэлтгэж, анх эфирт цацаж эхэлсэн бөгөөдүргэлжлэх хугацаа нь 1-2 цаг байдаг. Нэлээд удаан үргэлжилдэг нэвтрүүлэг гэж хэлж болно.Тус нэвтрүүлгийг санаачлагч П.Анужин хөтлөгч, продюссерээр ажиллаж байна. Мөн Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэн тус нэвтрүүлгийн нэгэн өнгө төрх болсон гэдгийг үзэгчид хүлээн зөвшөөрдөг. Найруулагчаар нь “Херо” студийн захирал Б.Баатар ажилладаг.Энэ нэвтрүүлгийн нэг гол онцлог нь оролцуулах хүмүүс нь олны танил, нэрд гарсан, салбар бүртээ манлайлагч болсон гадаад, дотоодын монгол хүн байдаг. Хүмүүс тус нэвтрүүлгийг үнэтэй хийгддэг гэж ойлгодог, нэн ялангуяа өвөр монголчууд маш өндөр үнэлж дугаар алгасахгүй үздэг.

Өвөр Монголын “Одон” телевизийн “Одод түгэх цаг” нэвтрүүлэг нь 2005 оноос анх гарч эхэлсэн бөгөөд өдгөө 12 жилийн нүүрийг үзэж байгаа, олон үзэгчтэй, агуулга, ур чадварын хувьд чанартай нэвтрүүлгүүдийн нэг юм.Тус нэвтрүүлэг нь долоо хоног бүр 30 минутын хугацаатай гардаг,монголчуудын дунд соёл урлаг, шинж-лэх ухаан, боловсрол зэрэг салбарт амжилттай, нэр төртай яваа

олны танил хүмүүсийг урин оролцуулдаг тогтмол нэвтрүүлэг юм. “Одон” телевизийн ток шоу нэвтрүүлгүүд Монгол Улсын телевизийн ток шоу нэвтрүүлгийн нэгэн адил студид явагд-даг боловч “Монгол тулгатны 100 эрхэм” студиэс гадна зочны төрсөн газар нутаг, ажиллаж амьдарч байгаа газар, байгууллага зэрэг олон газрыг сольж нэвтрүүлгийг улам сонирхолтой, үр өгөөжтэй болгохыг хичээдэг. 2016 онд Өвөр Моноглын алдарт дуучин Тэнгэрийг “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэгт урин оролцуулсан бол 2017 онд Монгол Улсын сэтгүүлч, яруу найрагч, хэл бичгийн ухааны доктор Л.Мөнхтөрийг “Одод түгэх цаг”нэвтрүүлэгт урин оролцуулсан билээ. Энэ хоёр нэвтрүүлгийг хооронд нь харьцуулах замаар ялгаатай болон төстэй талыг гаргахыг оролдоё.

Хоёр нэвтрүүлгийн аль алины уран бүтээлчид бүтээл дээр нэлээд ажиллаж, оролцогчоо сайн судлаж байж нэвтрүүлгээ бэлтгэсэн нь ажиглагддаг.“Одод түгэх цаг” нэвтрүүлгийн хөтлөгч Алимаа бол Өвөр Монголын залуу хөтлөгчдийн дунд нэлээд чадварлаг, хөдөлмөрч, шилдэг хөтлөгчдийн нэг юм. “Одод түгэх цаг”нэвтрүүлэг нь гадаад дотоодын олон шилдэг монгол уран бүтээлчийг урин оролцуулдаг учир хүн бүрийг судалж яриа өрнүүлэх нь амаргүй гэдэг нь тодорхой. Л.Мөнхтөр оролцсон ток шоу нэвтрүүлэгт Өвөр Монголд өргөн дэлгэрсэн “Зөв явбал зөөлөн зөөлөн замбулин” дууг зохиогдсон түүхээс асууж, яриагаа эхлүүлсэн нь үзэгчдийн сонирхлыг зүй ёсоор татсан байдаг. Цаашид “Нутгийн зам” дууг зохиосон түүх, радио телевизийн ажилд яаж орсон, гэр бүлийн тухай асууж, эцэст нь шинэ уран бүтээлийн тухай асуугаад

нэвтрүүлгээ жаргаасан нь нэгжээс ерөнхий руу шилжсэн, логик дараалал сайтай болжээ. Хөтлөгчийн эдгээр асуултууд нь оролцогчийг үзэгчдэд тодорхой хэмжээнд танилцуулсан, Монгол Улсын Л.Мөнхтөр хэмээх сэтгүүлч, яруу нарийагч, судлаачийн тухай бүрэн гүйцэд биш юмаа гэхэд тодорхой мэдээлэлтэй болсон нь ажиглагдсан боловч зөвхөн түүнийг уран бүтээл талаас нь хэт өнгөцхөн танилцуулж, түүний дотоод сэтгэл руу нэвтэрч чадаагүй юм. Өөрөөр хэлбэл тэр хүн юу боддог, юунд эмзэглэдэг, юунд баяралдаг, ямархан зан араншинтай гэдгийг мэдэх боломжгүй байлаа.

Харин “Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлгээс би дуучин Тэнгэрийн тухай маш их шинэ мэдээлэл олж чадсан.Б.Лхагвасүрэнгуай үнэхээр нүдээ олсон оновчтой асуулт асууж, зочноо яриулж чадсан байсан. Энэ бол юуны өмнө хөтлөгчийн хэнд ямар асуулт тавих вэ, үзэгчид түүнээс чухам юу хүсэн хүлээж байна вэ гэдгийг маш сайн мэдэрсэн, урьдчилж сайн бэлтгэсэн, бас туршлага, асуух ур дүйтэй холбоотой гэдэг нь тодорхой юм. Харин хөтлөгч дуучин Тэнгэрээс “Ар халхад ирэхэд та нарт ямар сэтгэгдэл төрдөг вэ?” гэдэг асуултаар нэвтрүүлгээ эхэлж, бас ярилцлагын явцад “Та нар ар монголчуудад хайртай, тиймүү? Яагаад тэгдэг вэ?” гэх мэтийн арай улстөржсөн, зочныг эвгүй байдал оруулахаарасуултууд тавьж байсан нь илүүц байсныг зориуд хэлэх хэрэгтэй. Ер нь энэ нэвтрүүлэг бүхэлдээ монгол үндэстний тухай яриа болж хувирсанд цөөнгүй үзэгч шүүмжлэлтэй хандаж байсан. Зохиогч миний бие Монгол Улсад төрж чадаагүй монгол хүний хувьд хэлэхэд үндэстэн гэдэг эмзэг сэдвийг хөндөхөд гадаад монголчууд нэртэй нэргүй, том

жижгээс үл хамааран бүгдээрээ үндэстний тухай хүнд сэдэв руу орчихоод байдаг, ингэх нь зөвхөн Өвөр Монголын төдийгүй Монгол Улсын үзэгчдэд хүртэл дэндүү эмзэг сэтгэгдэл төрүүлдэг. Цаг төрийн үймээн, түүхийн хувьслаар газар сайгүй байгаа гадаад монголчууд чинь Монгол Улсаараа бахархаж, зүрхний хайртай монгол ахан дүүсээ сангалзан байдаг тэр сэтгэлийг нь хөндөх нь илүүц мэт санагддаг.Харин Тэнгэр бол гадаадад монгол авьяас, монгол дүр төрх, монгол алдраараа асар их амжилт гарагсан гайхамшигтай уран бүтээлч. Тухайн нэвтрүүлгийн хувьд үзэгчдэд энэ алдар хүндэд яаж, ямар саад бэрхшээлийг даван туулж хүрсэн нь чухал байх учиртай юм. Харамсалтай нь хөтлөгчид уран бүтээлээс нь ярьж эхэлмэгц дундуур нь таслаад нөгөө үндэстний эмзэг сэдэв руу орж, улстөржсөн өнгө аяс оруулж байсан нь энэ нэвтрүүлгийн сул тал юм.

“Одод түгэх цаг” нэвтрүүлэг нь Өвөр Монголын үзэгчид сонирхон үздэг, бараг хүн бүхэн мэддэг шилдэг нэвтрүүлгүүдийн нэг. Тэгвэл “Монгол тулгатны 100 эрхэм” бол ганц Монгол Улс төдийгүй дэлхийн монголчуудын таашаалд хүрсэн нэвтрүүлэг болсон гэдгийг уран бүтээлчид нь анхааралдаа авч тус нэвтрүүлэгт хэнийг оролцуулах уу, оролцсон хүнээс юу асуувал дэлхийн монголчуудын сонирхлыг татах вэ гэдгийг сайн бодох хэрэгтэй.

“Монгол тулгатны 100 эрхэм” нэвтрүүлэг зураг авалтын хувьд асар их хүч хөдөлмөр, цаг хугацаа зарцуулсан нь ажиглагддаг. Тухайлбал, Тэнгэрийн төрсөн нутаг Өвөр Монголын Ордос, одоогийн сууж байгаа гэр орноос гадна зөвхөн Монгол Улсад маш олон газарт янз бүрийн байдлаар зураг авсан нь

нэвтрүүлгийг улам сонирхолтой, үзүүштэй болгожээ. Нэвтрүүлэг бүтэц зохиомж, найруулгын хувьд теле сэтгүүл зүйн мэргэжлийн түвшинд хийгдсэн гэдэгт эргэлзэх зүйл алга. Ганц жишээ дурахад Тэнгэрийн охин амьд байхдаа багваахай цэцэгт дуртай байсан гэдгээс санаа авч багваахай цэцгийн талаар дүрс бичлэг тавьж, нэрт яруу найрагчБ.Лхагвасүрэн охины тухай хэдэн мөр шүлэг уншсан нь үнэхээр сэтгэл хөдөлгөж, нулимсаа арчин байж үзсэн юм. Энэ бол агуулга ба хэлбэрийн нэгдлийг хангаж, ур чадварын өндөр түвшинд асар их хүч хөдөлмөр гаргаж хийсэн уран бүтээл хүнд яаж нөлөөлдгийн бодит жишээ юм. Хэдийгээр одоохондоо “Одод түгэх цаг” нэвтрүүлэгагуулга, хэлбэрийн хувьд ийм түвшинд хүрээгүй ч үзэгчдийг гадаад, дотоодын олон нэр цуутай монгол уран бүтээлч, эрдэмтэн судлаач, багш нарыг танилцуулж чадсанаараа чухал ач холбогдолтой юм.Мөн Өвөр Монголын “Одон” телевизийн үүрд хадгалагдан үлдэх үнэ цэнэтэй нэвтрүүлгийн нэг болсон гэдэгт эргэлзэхгүй байна.

#### Ишлэл

- <sup>1</sup> *Зулькафиль М.*2007.Чойсамба Ч. Америкийн сэтгүүл зүйн түүх УБ. х.109-110.
- <sup>2</sup> Мөн тэнд. х.110.
- <sup>3</sup>*Зулькафиль М.* 2016. Сэтгүүл зүйн тайлбар толь (Монгол бичгээр). Хөх хот.х.298.
- <sup>4</sup> *Ким Н.* 2001. Технология создания журналистского произведения. СПб. с.119.

- <sup>5</sup> См.: *Вартанов А.С.* 2003.Актуальные проблемы телевизионного творчества: на телевизионных подмостках. М.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Бүрээчин Дархан.* 2000. Дундад улсын сонин мэдээний түүх. Хөх хот.
2. *Вартанов А.С.* 2003. Актуальные проблемы телевизионного творчества: на телевизионных подмостках. М.
3. *Зулькафиль М. Чойсамба Ч.* 2007. Америкийн сэтгүүл зүйн түүх УБ.
4. *Зулькафиль М.* 2016. Сэтгүүл зүйн тайлбар толь (Монгол бичгээр). Хөх хот.
5. *Ким Н.* 2001. Технология создания журналистского произведения. СПб.
6. *Мэндхүү Г. Өнөрсайхан Т.* 2014.Телевизийн тухай А-Я хүртэл.УБ.
7. *Наранжаргал Х.* 2013. Телевизийн сэтгүүл зүй. Үндсэн ойлголт зөвлөмж УБ.

#### Резюме

Цель данной статьи заключается в сравнительном анализе телеинтервью-портрет “Монгол тулгатны 100 эрхэм” телевидений Монголии и ток шоу “Одод түгэх цаг” телевидения “Одон” Внутренней Монголии КНР. Автор сравнивая эти передачи выделяет особенности каждой передачи, в том числе положительные и негативные стороны вышеназванных передач. Автор делает вывод о том, что передача “Монгол тулгатны 100 эрхэм” отличается информационной насыщенностью, единством сдержания и формы, высоким мастерством режиссёра и ведущих, поэтому она стала одной из любимых передач аудитории Внутренней Монголии.